

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ 5 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2017 оны хоёрдугаар сарын 24-ний 09 цаг 05 минутад эхэлж, 10 цаг 05 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 1 цаг үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх зард бүртгүүлсэн иргэдийг нөөцөөс нэр дэвшүүлэх тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх зард бүртгүүлсэн Батчулуун овогтой Батмөнхийг Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалд, Лхагвасүрэн овогтой Мөнхзулыг Боловсрол, соёл, урлагийн газрын Монгол хэл, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалд, Дашгончиг овогтой Ганчимэгийг Татварын хэлтсийн Дэрэн сум хариуцсан татварын байцаагчийн албан тушаалд тус тус нэр дэвшүүлэв.
2	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлуулах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын 18 сул орон тоонд мэргэшлийн шалгалт зарлуулахаар ТАЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.
3	Ц.Идэр-Оргилын өргөдлийг хянан шийдвэрлэх комисс томилон ажиллуулах	Ц.Идэр-Оргилын өргөдлийг хянан шийдвэрлэх комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах тогтоолын төслийг батлав.
4	Х.Мөнхсаруулын өргөдлийг хянан шийдвэрлэх комисс томилон ажиллуулах	Х.Мөнхсаруулын өргөдлийг хянан шийдвэрлэх комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах тогтоолын төслийг батлав.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА